



Ц.Оюун  
МУБИС-ийн НХУС-ийн Монгол хэл, шинжлэлийн тэнхимийн багш,  
доктор (Sc.D), профессор

## БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛИЙН БОДЛОГО-СУРГУУЛЬ-БАГШ

**Abstract:** The nature of this article is to discuss the education reform policies in Mongolia. The need of implementation and promotion of those education reforms have been taken into consideration.

**Key words:** Education reform policies, trends and development, and school - teacher

XXI зууны иргэн мэдлэгтэй, чадвартай, төлөвшөн иргэн байх зорилтыг ЮНЕСКО-оос дэвшүүлж, ийм иргэн төлөвшүүлэх бодлого бүхий чанарын шинэчлэлийг 2012 оноос манай боловсролын салбар хэрэгжүүлж ирснийг багш бид мэдэх юм. Зөв монгол хүн өөрөө зөв шийдвэр гаргадаг, өөрийн бодолтой, өөрийгөө илэрхийлэх, өөрчлөх чадвартай байх зорилт дэвшүүлэн тавьж түүнийг хүүхэд ахуйгаас нь болон орь залуу насанд нь төлөвшүүлэх арга зам эрэлхийлж байгаа энэ цаг үед бид ажиллаж байна.

Улс орны өөрчлөлтийг боловсролын салбараас эхлэн суралцагч бүрийг өөрийнх нь хөгжлөөр хөгжүүлэх, сурах явцыг нь хамгийн ойроос эхэлж, мэдлэг чадвараа бүтээдэг чадамжтай иргэн болгон хөгжүүлэхэд чиглүүлж байгаа юм. Энэ чадамжийг бүр нэгдүгээр ангиас нь, мэддэг чаддаг дээр нь суурилж, хүүхдийг ярих, сонсох, унших, бичих, бодоход сурган учрыг нь олуулдаг чадвар суулгахаас эхлэх юм. Өнөөдөр суралцагчдын суурь чадварыг хөгжүүлж авьяасыг нээн гаргах, тэдний дотоод ертөнц рүү нэвтрэн орох сургалт чухал байгаа юм. Мөн суралцагч үйлдэн сурахуйн үед алдаж болно, харин алдаагаа ухаардаг, засаж чаддаг байх, багш энэ алдаанаас нь сургах аргагүйг нэгэн шинэ технологи хэмээн үзэх болж байна.

Боловсролын үндэсний хөтөлбөр, цөм агуулгыг боловсруулахдаа "Зөв монгол хүн" хөтөлбөрийн гаргалгааг баримталж хийх шаардлага урган гарч байгаа, үүнийг дагуулан суралцахуйн шинжлэх ухааныг оруулж ирж байгаа юм. Мөн хэрэгжүүлэх аргазүйдээ суралцахуйн үйлийг оруулж ирж,

сурах-сургахуйн судалгааг чухалчилж байгаа. Бид энэ шинэ бодлого, үзэл баримтлал, аргазүйн мэдээллийг бодлогын баримт бичгүүд, яамны тогтмол эмхэтгэл, вэб сайтууд, БСШУЯ-ны удирдлагуудаас олон нийтэд хандажхэлсэн үг, өгсөн ярилцлага зэргийг судлан үзсэнээр олж мэдэх боломжтой юм.

Монгол хүүхэд өнөөдөр ихээхэн өөрчлөгдөж байна. Багш, эцэг эхийн заасныг ойлгосон хэмжээндээ хийгээд, хэрэв ойлгоогүй бол тэгсхийгээд явж байдаг үе өнгөрөн одож, одоо өөртөө итгэлтэй, мэдлэгээ бүтээдэг, асууж лавладаг, өөрийгөө илэрхийлдэг, хийж бүтээх гэдгийг ухаардаг хүүхэд болж эхэлж байна. Ингэхийн төлөө ч багш ажиллах хэрэгтэй болж байна. Яамны шинэчлэлийн үзэл баримтлал, бодлогод, хүүхэд өөрийн бодолтой өссөнөөр өөрөөр бодох чадвартай, өөрийн гэсэн онцлогтой бүтээл хийдэг болон төлөвшихийн чухлыг заан тодорхойлсон. Яамнаас дэвшүүлж байгаа шинэчлэлийн үйл ажиллагаанд хүүхдэд хандлага, үнэт зүйл, хувь хүний зөв шинж чанар бүрдүүлэхэд анхаарсан нь бий. Энэ нь хүүхэд орчноо мэдрэх, нийгэмд өөрийгөө яаж авч явах, сурч сурахаас эхэлнэ. То вангийн сургаалд хүүхдийг хөлд ормогц нь дөрвөн зүг, найман зовхисыг таниулах тухай заасан нь дээрх зорилтод дүйж байгаа хэрэг.

Бусдыг хүндэтгэх, тэдэнтэй харилцах, зөвшилцөх, хамтрах зэрэг ардчиллын үзэл баримтлалыг сурагч байхаасаа эзэмших нь хүүхэд нэг бүрийн эрхэм үүрэг байх юм. Хүүхдэд хөгжих боломж олгож, орчин нөхцөлийг нь бүрдүүлж чадсанаар авьяастай, бүтээгч иргэд төлөвшинэ хэмээн үзэж энэ хэрэгт багш, эцэг эх, сургууль, эцэг эхчүүдийн ажлын газар, хамтрагч байгууллага нэгэн баг болж ажиллах учиртайг яам уриалж байгаа, энэ ажил биелэлээ олоход гар бие оролцон, санаачилж, холбогч нь мэдээж багш нар юм.

Өнөөдөр ерөнхий боловсролын сургуулийн багш мэдээллийн эх үүсвэр байх нь байраа тавьж өгч суралцагч төвтэй, хамтын сургалтад шилжив.



ЕБС-ийн багш мэдээлэл дамжуулахаас илүүтэй хүүхдийг дэмждэг, суралцах үйлийг тэтгэдэг, хүүхдийн авьяасыг нээн илрүүлж хөгжүүлэгч, номтой бүтээлчээр нөхөрлүүлэгч байх хэрэгтэй болж байна. Үүний тулд багш нь эрдэг хайдаг, хамтардаг, идэвхтэй, чадварлаг хүн байх шаардлагатай болж байна. Бусдын хийсэн бүтээснийг хэлбэрээр нь дуурайгаад байх бус, өөрийнхөө үр чадвар бүтээлч сэтгэлгээгээр оршин байх, ингэхийн тулд багш өөрийгөө хөгжүүлэх, шинэ аргазүй, зөв үйл, ёсзүйд төлөвших, бүтээгч байх хэрэгтэй болж байна.

Энэ ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор мэргэжлийн яам, хүрээлэнгээс “Багшийн хөгжил”, “Багш мэргэжлийн хөтөлбөр” хэрэгжүүлж багшийн хандлага ёсзүй, төлөвшил, нийгэмшлийн хэм хэмжээг дээшлүүлж эхэлж байгаа нь багш нарын талархлыг хүлээж байгаа билээ. Хүүхэд бүрийг хөгжүүлэх, тэдэнд тааруулж аргазүйгээ сонгодог, хүүхдийг мэдэрдэг, асуудлыг тулгадаггүй багш бэлтгэх нь багш бэлтгэдэг сургуулиудын анхаарлын төвд байна.

Хүүхдийн хэл иргэншилтэй холбогдуулан нэг жишээ хэлэхэд, хүүхэд эх хэлээ ойлгож ахуй амьдралдаа соёлтой хэрэглэж чадахгүй, үгийн сан нь хомс, утгын тайлбар толь, зөв бичихзүйн толь бичиг ашиглаж чаддаггүй байх нь түгээмэл үзэгдэл болсон. Энэ дутагдлыг ганц монгол хэлний гэх биш, бусад мэргэжлийн багш бүр заадаг хичээлээрээ хэлний чадамжийг нь дээшлүүлдэг, толь бичиг хэрэглэхэд нь сурган, тухайн шинжлэх ухааны хэлний суурь боловсрол олгох, ийм хэмжээний хэлний боловсролтой багш мэргэжил бүрээр хэрэгтэй байгааг ч яам асуудал болгон тавьж байгаа юм.

Мөн хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сайн арга технологи боловсруулах чадвартай, хичээлийн бэлтгэлийг өдөр тутамд сайн хийж чанартай боловсрол эзэмшүүлдэг, эцэг эхтэй харилцаа холбоотой, хамтарч ажиллан, хамтын хичээл, хамтын хөгжүүлэх ажил зохион байгуулж чаддаг, эцэг эх, тэдний албан байгууллагыг хүүхдийн төлөө сайн үйлсэд татан оролцуулж чаддаг бүтээлч багш өнөөдөр хэрэгтэй байна.

Ерөнхий боловсролын сургууль өнөөдөр хүүхдийг хөгжүүлэх, төлөвшүүлэхэд багш, эцэг эх, байгууллага, олон нийтийг зангидаж ажилладаг төв болж өөрчлөгдөх шаардлага бийг яам цохон тэмдэглэж байгаа. Ерөнхий боловсролын сургууль бүр “хүүхэд шуугьсан их өргөө” байхаасаа илүүтэй багшийн бүтээгч байр суурь, шинэ аргазүй, ёсзүй, хандлагыг өөрчлөхөд дорвитой зүйл хийн, үйл ажллагааны идэвхтэй орчин бүрдүүлж чадвал, хүүхэд тэрхүү идэвхтэй орчинд идэвхтэй болж, эцэг эх, багш ч идэвхжих болно. Үүнээс улбаалж бодлогын яамнаас хэрэгжүүлж буй хүүхдийн “Авьяас”, “Ном” хөтөлбөр ч амжилттай хэрэгжих хөрс болох юм. Ийм сургуулийн өмнөх боловсрол ба ерөнхий боловсролын хүрээнд “Хүүхэд”, “Авьяас”, “Ном” хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжсэн үр бүтээлтэй хөдөлгөөн хаа хаагүй өрнөж эхэлбэл

үр дүнд нь монгол хүүхэд хөгжих учиртай. Энэ хэрэгт сургууль, хүүхдийн цэцэрлэг, багш нэг бүр оройлон манлайлах ёстой байна.

Монгол Улсын Засгийн газрын “Зөв монгол хүүхэд” хөтөлбөрийн хүрээнд өсвөр үеийнхэний дунд ном унших аян өрнүүлэх, номыг бүтээлчээр унших аргазүйг түгээн дэлгэрүүлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа “Ном” дэд хөтөлбөрийг дэмжсэн сургууль номын сангаа баяжуулан, анги бүрийг номын сантай болгож байгаа хэдий ч бүх нийтийг хамарч чадахгүй, эцэг эхчүүдийн санаанд тэр бүр хүрч чадахгүй байгаа юм. Цаашид энэ ажлыг сургууль, багш бүр дэмжиж өрнүүн хөдөлгөөн болгох, мөн яамнаас шинээр нэвтрүүлээд байгаа цахим сурах бичгүүдийг багш, сурагч, эцэг эхийн гуравласан холбоогоор нээлттэй ашиглуулж сургахад санаачилга гаргах хэрэгтэй байгаа юм.

Сургуулийн өмнөх боловсрол Хүүхэд насны хөгжлийн хамгийн чухал үе нь сургуулийн өмнөх нас тул хөгжил төлөвшил, ёс суртахууны дөчөөд хувь нь тав хүртэлх насанд бүрэлдэн бий болдог байна.

Иймд хүүхдийг цэцэрлэгт хамрах хүрээг нэмэгдүүлэх, цэцэрлэгүүдийг баялаг тоглоом бүхий хөгжлийн төв болгох нь тулгамдсан асуудал болоод байгаа. Сургуулийн өмнөх боловсролд эн түрүүнд зөв ёс суртахуунтай хүүхэд, цэвэрч цэгцтэй, өөртөө арчтай зөв хүүхэд болгох, суралцахуйн эерэг хэрэгсэл болох тоглоход хүүхдийг сургах, тоглох үйлд соёлтой оролцох, тоглож чадахад хүүхэд анхаарлаа хандуулж сургахад хүмүүжил төлөвшлийн гол агуулга оршиж байна. Иймд хүүхдийн цэцэрлэгийн тоглоомд ахуйн сэдэвтэй, үйл явдалтай, орчинтой, иж бүрэн тоглоомыг олшруулах нь эрхэмлэх зүйл болж байгаа юм. Учир нь, тоглож сурахад үүссэн мэдлэг мартагддаггүй ажээ.

Сургуулийн өмнөх боловсролд үг, авиаг зөв дуудахаас эхлэн эрхлэх дууг үл гаргаж, ярих, зурах, бүтээх, сэтгэх, ойлгох анхан чадвартай, зөв хүмүүжил төлөвшилтэй, зөв ёс суртахуунтай зөв хүүхэд болгон өсгөж хүмүүжүүлэх нь зөв хүн төлөвшихийн суурь боловсрол болно. Сургуулийн өмнөх насны боловсролын хүрээнд хүүхдийн авьяасыг бага балчраас нь илрүүлэн зөв хөгжүүлэх, эрүүл чийрэг хүүхэд болгоход чиглэсэн агуулга хөтөлбөр боловсруулж, шинэ хандлага аргазүйг нэвтрүүлэх нь боловсролын хүрээлэн, боловсрол төв, хүүхдийн цэцэрлэг, багш хүмүүжүүлэгчдийн тэргүүн зорилт болох нь илэрхий байна. Мөн сургуулийн өмнөх боловсролын хэрэгжилтэд эцэг эх, хүүхдэд ээлтэй хандагч байгууллага хамт олны үйл ажиллагааг хандуулан хамтрах нь чухал билээ.

Сургуулийн өмнөх боловсролын багш хүмүүжүүлэгч, үйлчилгээний ажилчдын бүтээгч байр суурь, хандлага төлөвшил хэдий чухал ч, түүнээс илүүтэй нь хүүхдэд хайртай, хүүхдийн сэтгэлзүйг ойлгон хүүхдийн сэтгэлгээгээр амьдарч ажиллаж чадах, хүүхдэд бүхнээ зориулах, ухаалаг, энэрэнгүй хүн байх нь илүү

үнэ цэнтэй төдийгүй, чанартай үйлчилгээний үндсийн үндэс болох юм.

Дээд боловсролд тоог бус чанарыг эрхэмлэн, практикт түлхүү суурилсан шинэчлэлийг чухалчлах бодлогыг БСШУЯ-аас барьж байна. Мөн монголын эдийн засагт борлуулалтаар өндөр хувь нэмэр оруулах салбар бол эдийн засгийн нэг бүрэлдэхүүн хэсэг болох "бүтээгч дээд боловсрол" хэмээн томъёолж байгаа билээ. Дэлхийн эдийн засагт чухал хувь нэмэр оруулах өндөр орлогын эх үүсвэр гэдэг нь тодорхой болсон зүйл бол шинэ технологи, шинжлэх ухаан хоёр юм. Иймд БСШУЯ монгол шинэ технологи, шинжлэх ухаан хоёрыг зах зээлд гаргах, үүний тул дээд боловсролын салбар бүхэлдээ шинэ мэдлэг, чадвар, хандлагын төлөө явах, инженер, эрдэмтэд дээрээ суурилж бүх зүйлээ авч явах бодлого барьж байгаа, энэ нь бодлогын баримт бичгүүд болон удирдлагуудын мэдээллээс харагддаг.

Яамны бодлогоос үзвэл нэлээд олон чиглэлээр томоохон шинэчлэл хийхээр шийдвэрлэсэн байдаг. Тухайлбал,

- Дээд боловсролын салбараас чадварлаг эрдэмтдийг олноор гарган, улмаар шинжлэх ухаанд том нээлт, алхам хийх, шинэ технологи бүтээхэд ойрын жилүүдэд их анхаарах төлөвтэй байна. Үүний тулд боловсрол дахь судалгааг ихээхэн өндөрт тавих ба боловсрол судлалыг тэргүүлэх шинжлэх ухаан болгон хөгжүүлэх зорилт тавьж байна.
- Яамнаас гадаадад оюутан олноор сургаж гаднаас шинжлэх ухааны шинэ онол, аргазүй, технологи оруулж ирэхэд багагүй хөрөнгө зарж байна. Энэ онд гэхэд л Орос улсад 383 оюутан, засгийн газрын тэтгэлгээр 85 оюутан, магистрантур, докторантурт 50-иад хүн сургахаар явуулсан байна. Үүний цаад зорилго нь "Эрдэмтэн ба эдийн засаг", "Бүтээгч ба бүтээмж"-д суурилах шинэ бодлого хэрэгжихэд зорих явдал ажээ.
- Дээд боловсролын сургалт энэ жилээс хуулинд заасны дагуу мэргэжилтэн бэлтгэх бус, дээд боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх чиг үүрэгтэйг үндэслэн бакалаврын сургалт өргөн суурьтай хөтөлбөрөөр явж эхэлсэн.
- Оновчтой бүтцэт сургууль болгохын тулд их сургуулиуд бүтцийн өөрчлөлт хийж бүтцийн давхардлыг арилгаж эхэлж байгаагийн зэрэгцээ сургалтын чанар, нийлүүлэлтийг суралцагч, ажил олгогч, олон нийтийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэхэд анхаарч ажиллах юм. Манай улс дээд боловсрол эзэмшихээр суралцагчдын тоогоор аль ч орноос доогуур биш бөгөөд монголын гурван сая орчим хүнээс 300 мянгаад оюутан сурч байгаа нь дэлхийн хэмжээнд их дээгүүрт тооцогддог ажээ.
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас дэвшүүлэн тавьж байгаа нэг томоохон асуудал нь их, дээд сургуулийн багш нар суралцагч оюутан, магистрант, докторантын мэдлэг, чадвар, хандлагад чанарын өөрчлөлт гаргахад дорвитой алхам хийх, үүний эхлэл их, дээд сургуульд элсэгчдийг өндөр шалгуураар

орлуулахаас тавигдана хэмээн үзэж байна. Мөн дээд боловсрол эзэмшихийн суурь мэдлэг чадвар хангагдаагүй, нийгэмшил, хандлага төлөвшил суугаагүй хэн дуртай нь дээд сургуульд элсэн сурах болсон нь дээд боловсролын чанар хангалтгүй байгаагийн нэг сул тал хэмээн яам үзэж байгаа юм. Үүнээс үүдэн яамны барьж байгаа зарчмын нэг зүйл болох, дээд сургуульд элсэгчдийн босго оноог өндөрсгөх, цаашид "арын хаалга"-аар сургуульд орох, төгсгөх, гүйлгээр дүн авахыг хааж дээд боловсролыг арын хаалгагүй болгоно хэмээн мэдэгдэж байгаа. Энэ эхлэл биелэлээ олж байгааг энэ жил их дээд сургуульд танилаараа гүйлгэж элсэх явдал эрс хумигдсан байдлаас харж болно.

- Дээд боловсрол эзэмших сууриа бүрэн хангаж чадсан элсэгчдэд өнөөдөр, сонголт гол зүйл нь болоод байгаа. Тэд эхлээд элсэх сургуулиа, дараа нь хөтөлбөрөө, удаад нь заалгах багшаа сонгох, улмаар нэгдүгээр анги төгсөхдөө эзэмших нарийн мэргэжлээ сонгох болж байгаа юм. Өнөөдөр улс оронд маань мэддэгээс чаддаг, чаддагаас хийдэг, бүтээдэг хүн хэрэгтэй байна. Эл чиглэлээр яамнаас дэвшүүлэн тавьж байгаа шинэ бодлогын нэг нь оюутан, магистрант, докторантад өөрөө сурах боломж олгох, багш заах зүйлээ онлайнгаар өгөх, улмаар оюутантайгаа ажиллаж хөгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны дөртэй болгох, бүтээх хийх, турших сэтгэлгээтэй болгон төлөвшүүлэхийг урдаа тавьсан зорилт болгох явдал гэж үзэж байна.

Мөн багш өөрөө эрдэм судалгааны ажил хийж улс оронд чухал хэрэгцээт дэвшил бүхий нээлт, бүтээл гаргахад хүч оюунаа зарах ёстойг уриалж байгаа. Эдгээр зорилтоо хангахаар яам анх удаа "Боловсролын салбарын мэдээллийн систем"-ийг шинээр нэвтрүүлжээ. Ингэснээр бүх шатны боловсрол эзэмшигчид олон эх үүсвэрээс мэдээлэл авах боломжтой, нээлттэй болох юм байна. Энэ мэдээллийн систем нь суралцагч, багш, үйлчилгээ авахыг хүссэн албан байгууллага, хэн бүхэнд агуулга, чиглэлээр адил ч хэрэгцээний нь зориулалтаар түвшин ялгаатай байх ажээ. Уг мэдээллийн нэгдсэн систем нь их, дээд сургуулийн үйл ажиллагаанд хяналтын системээр холбогдох боломж нээхийн зэрэгцээ, хуурамч диплом, үнэт цаас худалдан борлуулагчдыг суралцагчдын код мэдээллээр дамжуулан илрүүлэх боломжтой болох юм байна. Ер нь их, дээд сургуулийн суралцахаас үнэлж дүгнэх хүртэлх бүх л үйл ажиллагаа мэдээлэл харилцааны дэвшилтэт технологид тулгуурлах зорилго руу явж байгаа нь яамны шинэчлэлийн нэг хэсэг нь байна.

- Оюутан, магистрант, докторантын суралцах үйл ажиллагаа нь суралцагч төвтэй, тэдний оролцоог дэмжсэн, үйлээр дамжуулан сурах, төсөлд суурилсан, идэвхтэй арга голлоход чиглэнэ. Мэдээллийг боловсруулах, мэдлэгээ хэрэглээнд хувирган бүтээх чадвар, тусган



авах, шинжих, тунгаах, логик гаргалгаа хийх, учирзүй, уялдаа холбоог тодорхойлох чадвар гэх мэт чадварыг өнөөдрийн сургалтад онцлон үзэх болж байгаа билээ. Суралцагч мэдлэгийг хэрэглэгч төдийгүй, бүтээгч байх учиртай хэмээн үзэж буй тул багшийн сургалт оюутанг сэтгэх идэвхтэй үйлийн хандлагад хөтлөх аргаар тухайлбал, Блуммийн схемээр, илэрхийлэх ур чадвар, чөлөөт сэтгэлгээний ур чадвар, бүтээх ур чадвар эзэмшүүлэх, оюун дүгнэлт, аналогий шийдэл гаргах зэрэг олон хувилбарт уян хатан чиглэлээр явах нь чухал болж байна. Оюутан, магистрант, докторантууд ч өөрөө сэтгэлгээний боловсрол эзэмшихэд хичээх нь сурах-сургахуйн шинэ хандлага болж байна.

- Оюутны авьяас, сэтгэх чадварыг хөгжүүлэн дэмжсэнээр хийж бүтээдэг, чаддаг мэргэжилтэн болгон нийгмийн салбаруудад бэлтгэж өгөх нь их, дээд сургуулийн нэг үүрэг байна. Их сургуульд суурилсан шинжлэх ухаан, шинэ шинэ мэдлэгт суурилсан дээд боловсрол өнөөдрийн болоод алсын хараа нь болсон байна.
- Их сургуулиуд нь судалгаагаа хийж чаддаг, бүтээл, мэдлэг, судалгаагаа зарж чаддаг байх хэрэгтэйг багш бид ч бас анзаарч байна. Яамнаас авч байгаа өөр томоохон алхам бол их сургуулиудыг шинжлэх ухааны төв болгох явдал бөгөөд энэ ажил нь боломжит хурдаараа явж, анхны шинжлэх ухааны паркийг барьж байгуулах, шинэ нээлт, бүтээгдэхүүн гаргаж инноваци болгох ирээдүй нь тийм ч хол бус, ойрхон байгаа юм. Энэ эрхэм зорилго хэрэгжсэнээр манай орны эдийн засагт томоохон, шинэ алхам болох ажээ.
- Мөн шинжлэх ухаан технологийн төсөл, инновацийн төсөл, мэдлэг чадвар, бүтээмжийн өрсөлдөөнд шинэ алхам хийж, түүнд багш бүр хамрагдахыг яам болон, ШУТИС, МУИС зэрэг их сургууль ихээхэн анхаарч байна. Ингэснээр эрдэмтдийн хүчээр шинжлэх ухаан-эдийн засгийг босгож, улс орны хөгжилд дэвшил авчирна хэмээн тооцож байгаа юм байна.
- Их сургуулиудын үүргийг, сурч чаддаг, нийгэмшин төлөвшсөн, өөрийгөө илэрхийлэх чадамжтай, мэддэг чаддаг-хийдэг бүтээдэг иргэн төлөвшүүлэн төгсгөж гарах явдал хэмээн яам үзэж байна. Үүний тул оюутны суралцахуйг дэмжих төвийг их, дээд сургууль бүр байгуулж туслалцаа үзүүлэх хэрэгтэйг зөвлөж байгаа билээ. Их, дээд сургуулиуд ч мөн багш нар нь оюутан, магистрант, докторанттайгаа ажиллах, зөвлөн чиглүүлэх боломжийг нэмэгдүүлэн, тогтвортой цаг хугацаа, анги танхимыг расписанчилан гаргаж өгч байгаа юм. Мөн багш нар эрдэм

шинжилгээний ажлыг үр бүтээлтэй хийж шинэ технологи, бүтээл, онол, аргагүй, бүтээгдэхүүн гаргахыг тэдний үүрэг хэмээн үзэж байна. Өөрөөр хэлбэл, самбарын өмнө зогсох цагаас суралцагчидтайгаа үр бүтээлтэй ажиллан хөгжүүлэх цагийг эн тэргүүн бодлого болгож байна. Ингэснээр, дээр дурдсан шинэчлэгч, бүтээгч, өндөр боловсролтой мэргэжилтэн төрүүлж үр дүнд нь шинжлэх ухаан, технологи, инноваци, эдийн засаг хөгжих язгуур бодлого хэрэгжих боломж бүрдэнэ хэмээн Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам томъёолж байгаа билээ. Энэ чиглэлийн ажлыг МУБИС амжилттай хийж гүйцэтгэж байгааг эрдэмтэн багш бид дэмжин харж, үйл ажиллагаанд нь ч оролцсоор байна. МУБИС-д шинэчлэлийн үйл ажиллагаа эрчимжин одоогоор багшийн болон санхүүгийн, оюутны үйл ажиллагааны журмууд гарч, улмаар эрдэм шинжилгээ-инновацийн, эрдмийн зөвлөлийн зэрэг журмууд боловсруулах шатандаа явж байгаа юм.

- Өнөөдөр их, дээд сургуулийн сургалт, судалгаа зах зээлийн эрэлт хэрэгцээ, үндэсний хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдахгүй байгаа, сургалт, судалгааны стандартыг шинэчлэх, чанарын баталгаажуулалтын системийг үр дүнтэй ажиллуулахад анхаарах шаардлага бийг яам анхааралдаа авч, боловсролын хөгжлийн бодлогын зорилт-2021 хөтөлбөрт дээд боловсролын тогтолцоо, агуулга, стандартыг шинэчлэн сайжруулж, олон улсад өрсөлдөх чадвартай, олон улсын жишигт нийцсэн их, дээд сургуулиудыг бий болгосны суурин дээр үндэсний шинжлэх ухаан, технологийн дэвшил хийхээр стратеги зорилго, зорилтуудыг дэвшүүлжээ. Энэ ажлуудын эхнийх нь их, дээд сургуулиудын бакалаврын мэргэжлийн чиглэл, хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг хөтөлбөрийн загвар, зөвлөмжийн хамт яамны сайдын 2014 оны А\174 тоот тушаалаар шинэчлэн баталж гаргасныг нийт их, дээд сургууль хэрэгжүүлэн хөтөлбөрөө шинэ загварт нийцүүлэн боловсруулж эхэллээ. МУБИС гэхэд л одоо бакалаврын сургалтын багцын ба судлагдахууны багц хөтөлбөрүүдийг боловсруулж байна.
- Их, дээд сургуулийн багшийн тухайд мэргэжлийн яам тодорхой дүр зураг гаргасан бөгөөд түүнээс зарим зүйлийг үндэсний телевизүүдэд сайд, удирдлагууд "Боловсрол дахь шинэчлэлийн бодлого" сэдвээр өгсөн ярилцлагаас эшлэн хүргэвэл, Их, дээд сургуулийн багш нь шинэ онол, шинэ нээлт, бүтээл гаргадаг, практикт шинэ аргагүй, технологи нийлүүлэгч, шинжлэх ухаан хөгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг

хүн байх учиртай. Түүнээс бус зүгээр нэг хичээл заан хүмүүсийн хийсэн бүтээсэн зүйлийн тухай мэдээлэл дамжуулдаг, суралцагчдын төлбөрөөр амьдардаг хүн өнөөгийн их, дээд сургуульд гологдох болж байна хэмээн мэдээлсэн нь бий. Үүнээс үзвэл ямартай ч дээд боловсрол олгогч багшид тавих шаардлага, хэмжүүрт шинэ баримтлал тавигдах нь тодорхой байгаа. Энэчлэн тухайн сургууль онцлогоосоо үүдэн багшид тавих тусгай шаардлагыг нэмж тодорхойлно хэмээн бакалаврын мэргэжлийн чиглэл, хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага (яамны сайдын 2014 оны А\174 тоот тушаал)–д мөн заасан байгаа. Энэ бүхэн их, дээд сургуульд төрөөс тавьж байгаа улс орныг хөгжүүлэх хөшүүрэг бол дээд боловсрол хэмээх зарчмын үзэл баримтлалаас урган гарч байгааг багш бид дэмжин, хувь хүний зорилго, зорилтоо өөрчлөн, нийцүүлж ажиллах шаардлага бий юм.

- Мэдлэгт суурилсан бодит шинэ бүтээл бол инноваци байна, их сургууль судалгаа хийж, шинэ бүтээл гарган эдийн засаг руу нийлүүлдэг байхыг яам хүсэн хүлээж байгаа юм. Мөн магистр, доктортойгоо багш нар нь хамтарч шинэ зүйл бүтээдэг, ахмад эрдэмтэн судлаачид нь залуу эрдэмтэдтэй хамтарч ном, эрдэм шинжилгээний ажил хийх санал санаачилга, уриалгыг мэргэжлийн яам маань дэвшүүлж байгаа юм. Тэрчлэн инновацийн төсөл хэрэгжүүлж байгаа ба залуу эрдэмтэд хийгээд ахмад эрдэмтдийг илүүтэй дэмжин тэдний оюун ухаан, эрч хүч, эрдэм, туршлагыг хэрэглэх бодлого барьж байгаа ажээ. Энэ бодлого МУБИС-д сайн хэрэгжиж байгаа бөгөөд нийт багшийн дунд цахим хэлбэрээр хэлэлцүүлэн нягт чамбай боловсруулан захирлын 2014 оны А\186 дугаар тушаалаар баталгаажуулж гаргасан “МУБИС –ийн багшийн ажиллах журам” нэгэн үр дүн нь юм.
- Дээд боловсрол дахь чанарын шинэчлэлд инженерийн ба технологийн боловсролыг ихээхэн чухалчилж байна. Шилдэг инженер, дэлхийд өрсөлдөх инженерийн боловсролд Япон, боловсролоор өмнөд Солонгос, шилдэг технологиор Герман тэргүүлж байдаг байна. Манай улсын дээд боловсролд эдгээр орон жишиг болох бөгөөд тэдгээр орон руу боловсрол эзэмшүүлэхэд их анхаарч байгаагийн зэрэгцээ, хожмын нэгэн үед эдгээр орныг монгол инженерийн боловсрол, монгол шинэ технологиор давсан байх алсын хараагаар ажиллах хэрэгтэйг дээд боловсролын салбар, их сургууль, эрдэмтдэдээ яам маань сонордуулан уриалж итгэл хүлээлгэсэн.

Энэ чухал бодлогоо хэрэгжүүлэхийн төлөө эрдэмтэн-шинжлэх ухаан-эдийн засаг-

боловсролыг нэгэн цул хүч болгон зангидаж үйл ажиллагааг нь дэмжсэнээр улсын хөгжлийг өөд татах, үсрэлт хийх, хүчтэй бодлого явуулахаа яам илэрхийлж байгааг манай эрдэмтэн, багш нар дэмжиж, гар бие оролцон оюун ухаан, эрч хүчээ нэгтгэх нь эрхэм зүйл байх болно.

Иймд их, дээд сургуулийн удирдлага, эрдэмтэн багш, эрдэм шинжилгээний ажилтан бүр энэ бодлогын шинэчлэлийг ажил болгохын төлөө явах, хүн бүр эрхэм зорилго, төлөвлөлтдөө тусгал болгон шинэ хандлага, арга барилаар ажиллахаас хүрэх үр дүн, ирээдүй маань шалтгаалах билээ.

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Бадарч, Б. (2014). *Дээд боловсролын инноваци*  
Мөнхжаргал, Д. (2013). Монголын багш боловсролын шинэчлэл. *Лавай*, 10, 4-8
- Орхон, Г. (2014). Дээд боловсролын суурь хичээлийн сургалтын хөтөлбөр, сургалтын хэлбэр, заах аргыг шинэчлэхэд
- Очирбат, Б. Мэргэжлийн чиглэл, индексийг хөтөлбөр болгосноор инженерүүд хөрвөх чадвартай болно
- Монгол Улсын Засгийн Газар. (2010-2014). БШУЯ-ы үйл ажиллагааны үзэл баримтлал, бодлогын баримт бичгүүд, эмхэтгэл, гарын авлагууд *Дээд боловсролын шинэчлэлийн зураглал 2010-2021*
- Боловсрол Шинжлэх Ухааны Яам. (2014.4.28). А/174 тушаал
- “ШУБЯ –ны шинэчлэлийн бодлого” нэвтрүүлэг. UB TV, TV-25
- БШУЯ–ын сайд Л.Гантөмөр, Л.Лувсанжамц, Насанбаяр, Д.Мөнхжаргал, Х,Тамир, А.Түяа, Л,Цэрэнсодоном, Ням-очир. (2014). ТВ ярилцлага
- Боловсрол Шинжлэх Ухааны Яам. *Мэргэжлийн чиглэл, индекс*
- Монгол Улсын Боловсролын Их Сургууль. (2014). Багшийн ажиллах журам. А/186

[www.qualityresearchinternational.com/glossary/](http://www.qualityresearchinternational.com/glossary/)

[www.ncle.mn](http://www.ncle.mn) Насан түршийн боловсрол